



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 0/455

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Төрийн Өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 469 дүгээр тогтоол, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Ардын Засгийн газраас хандивласан нийт 12,000,000.00 (арван хоёр сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 11/45 дугаар тушаалын хавсралт

Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ /төгрөгөөр/		Хөрөнгө оруулалтын шийдвэр болон хандивлагчийн нэр	Хөрөнгийн эх үүсвэр
							нэгжийн үнэ	нийт дүн		
1	Ухаалаг дэлгэц	Хуавэй	2023	сайн	ком	1	12,000,000.00	12,000,000.00	БНХАУ-ын ӨМӨЗО-ы Ардын засгийн газар /Гадаад харилцааны яам/	Хандив
	Машин, тоног төхөөрөмжийн дүн							12,000,000.00		